

Ч.ТАМИР

МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш, Социологич

Б.ЭРДЭНЭ

IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач

ДОЛООН САРЫН НЭГНИЙ ҮЙЛ ЯВДАЛД ХИЙХ СОЦИОЛОГИЙН ШИНЖИЛГЭЭ

Abstract: *The research aims to explain the event of July 1st 2008 by using a sociological theory of collective behavior and particularly the theory of six elements of analysis proposed by Neil Smelser and while conducting a photo analyses. Processes of the July 1st event are analyzed with six determinants of collective behavior and there are the following: Structural conduciveness, structural strain, spread generalized believes, precipitating factors, coordinated group, operation of social control. Hypothesis is the mass protest in July 1st was an expression of people's attitude towards social issues which is characterized by their decreasing trust in state and increasing corruption. Author concluded main reasons for collective action to take place in Mongolia are corruption and social inequality. Increased bureaucracy and unequal service quality that imply discrimination affect the majority of people who have low income. This leads people to show less trust in governmental institutions and in consequence, many people have become willing to actively participate in collective actions.*

Key word: *Structural conduciveness, structural strain, spread generalized believes, precipitating factors, coordinated group, operation of social control*

А. УДИРТГАЛ

Монгол улс чөлөөт ардчилсан дэглэмд шилжиж, үндсэн хууль, парламентын засаглалтай болсноор даруй 20 гаруй жилийг үджээ. Энэ хугацаанд шинээр баталсан үндсэн хуулийн дагуу УИХ-ын сонгуулийг 5 удаа явуулаад байна. Үндсэн хуульд монгол улсын иргэн сонгох, сонгогдох эрхтэй гэж заасан ч сонгуулийн дараа сонгогчийн эрх зөрчигдсөн, сонгуулийн хуулийг зөрчсөн булхай гарч байгаа талаарх гомдол, маргаан сүүлийн хоёр удаагийн сонгуулийн дараа олноор гарах боллоо. Сонгуулийн зөрчлийн энэ асуудлыг системтэйгээр судлах ажил нь 2004 оноос эхэлсэн гэж үзэж болно⁶⁸.

Өгүүллийн зорилго нь 2008 оны УИХ-ын сонгуулийн дараа гарсан олон нийтийн эсэргүүцэл, жагсаал, мөн олон нийтийн хүчирхийллийг социологийн үнэт зүйлийн онолыг ашиглан судлах гэсэн оролдлого юм. Чухам ингэж онцолж үзэх болсон шалтгаан гэвэл нэгдүгээрт, 2008 оны долоон сарын нэгний өдөр болсон энэ үйл явдал нь сонгууль булхайтай явагдсан гэж олон мянган иргэд сонгогчид үзэж, олон нийтийг хамарсан жагсаал цуглаан хийж, улмаар монголд анх удаа өргөн хүрээг хамарсан олон нийтийн хүчирхийлэл (public violence) болсон, *хоёрдугаарт*; Монгол улс түүхэндээ анх удаа олон нийтийн дэг журам алдагдсантай холбоотойгоор “Онц байдал” зарлаж, хэвлэл мэдээллийн хэрэгслийг анх удаа хаасан; *гуравдугаарт*; олон нийтийн хүчирхийлэл эмх замбараагүй байдлын үеэр 5 хүн амиа алдаж, олон зуун хүн бэртэж гэмтэн, 780 хүнийг албадан баривчилж, 250 гаруйд нь шүүхээс ял оноож, барилга байшин, соёлын өв шатааж олон сая төгрөгний хохирол учруулж; *дөрөвдүгээрт*; уг үйл явдлын дараа тухайн үйл явдалд оролцсон гэх үндэслэлээр иргэдийг “хоморголон баривчилж”⁶⁹, түр саатуулах явцад хүний эрх зөрчигдсөн явдал зэрэг юм.

Энэхүү өгүүлэл Ч.Тамирын удирдсан “Улс төрийн эсэргүүцэл ба олон нийтийн мобилизаци: Киргизийн “алтан зулын хувьсгал” ба “Монголын долоон сарын нэгний үйл явдлын харьцуулсан судалгаа” сэдэвт 2009-2014 онд хэрэгжиж байгаа төслийн хүрээнд хийгдэж байгаа судалгааны ажлын нэг хэсэг болно⁷⁰.

⁶⁸ Ч.Тамир Сонгуулийн булхай. Өнөөдөр 2004 оны 8 сарын 17 <http://forum.mn/old/print.php?coid=455>

⁶⁹ Онц байдалтай холбоотой хүний эрхийн зөрчлийн мониторинг, хамгааллын эвсэл. (2008). *Баримтжуулалтын тайлан*. УБ., 7 тал

⁷⁰ Энэхүү төслийн 2008-2010 онд CARTI төсөл, 2010 онд ННХ-гийн Дээд боловсролыг дэмжих хөтөлбөр, 2011 онд Европийн холбооны СОИМБРА бүлэг тус тус санхүүжүүлсэн болно.

В. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Долоон сарын нэгний үйл явдлыг АНУ-ын нэрт социологич Н.Смелзерийн “өсөн нэмэгдэх үнэт зүйл”-ийн онолын үүднээс судалж тайлбарлахыг оролдсон болно. Үүний тулд долоон сарын нэгний үйл явдлын нөхцөл байдлын талаарх оролцогчдоос авсан ярилцлага, мөн үйл явдлын фото зурган дээр шинжилгээ хийж “QDA- miner” хэмээх чанарын шинжилгээний программ ашиглаж боловсруулсан. Ингэхдээ бид тоон ба чанарын шинжилгээний аргуудыг хослуулан хэрэглэхийг хичээсэн билээ. Чанарын судалгааны “QDA- miner” программыг албан ёсны лицензийн⁷¹ эрхтэйгээр ашиглаж үр дүнг нь гаргав. Мөн нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдийг харьцуулан ялангуяа таамаглалын дагуу иргэдийн авлигын талаарх санал бодол ба төрд итгэх итгэл дээр илүү төвлөрсөн нь шинэлэг болсон гэж үзэж байна.

Уг үйл явдлаас хойш үүнийг судлах оролдлогууд ямар нэгэн хэмжээгээр хийгджээ. Үүнээс нэлээд томоохон ажлуудыг дурдвал Кембрижийн их сургуулийн профессор Дэвид Снит нарын *Пост социализмийн төгсгөл? Монгол улсын Улаанбаатар хотод болсон 7 сарын 1-ний үймээн* гэсэн өгүүлэл Дотоод Ази (Inner Asia, 2009) сэтгүүлд хэвлэгдсэнийг дурдах хэрэгтэй⁷². Уг өгүүлэлд уг үйл явдлыг он цагийн дэс дараалал болон үйл явдалтай холбоотой хүмүүсийн өгсөн тайлбар зэргийг дурджээ.

Мөн Кембрижийн их сургуулийн монгол судлалын төвөөс 2009 оны 4-р сарын 17-ны өдөр зохион байгуулсан “Монголын улс төрийн тогтвортой байдал” хэмээх хурал, түүнд тавигдсан илтгэлүүдийг дурдах хэрэгтэй. Тус хуралд монгол судлаач Ален Сандерс болон тухайн үед Кэмбрижийн их сургууль магистрантаар суралцаж байсан П.Онон болон тус сургуульд судалгаа хийж байсан Зульфикар нарын хамтарсан илтгэл, мөн Сант-Андрюсийн их сургуульд судалгаа хийж байсан МУИС-ийн багш Ч.Тамир нар илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна. Алан Сандерсийн илтгэл нь уг үйл явдлын өмнө болж байсан жагсаал цуглаануудыг түүхчилсэн байдлаар авч үзсэн бол П.Онон нарын илтгэл нь нийгэм эдийн засаг, улс төрийн нөхцөл байдалтай харьцуулан шинжилгээ хийхийг оролдсоноороо онцлог юм. Харин МУИС-ийн багш Ч.Тамирын илтгэл⁷³ нь “7-р сарын 1-ний үйл явдалд хийх судалгаа” нэртэй бөгөөд илтгэлд долоон сарын өмнөх нийгмийн нөхцөл байдал болон үйл явдлын агуулгыг Киргизийн “алтан зул”-ын хувьсгалтай харьцуулан судалсан юм. 2009 оны 9 сард Унгарт Төв Европийн их сургууль дээр “Төв Азийг судлах Европийн нийгэмлэг”-ээс зохион байгуулсан хуралд Ч.Тамир⁷⁴ “Пост социалист орнууд дахь нийгмийн хөдөлгөөн” нэртэй илтгэл тавьсан бөгөөд үүндээ тухайн өдрийн үйл явдлын хронологи, судалгааны ажлын хэрэглэгдэхүүнийг нарийвчлан гаргажээ.

Мөн Монголын ННФ-аас “Онц байдалтай холбоотой хүний эрхийн зөрчлийн мониторинг, хамгааллын эвсэл, *Баримтжуулалтын тайлан*”-г хэвлэн гаргасан нь ихээхэн хэмжээний тоо баримттай материалыг агуулжээ. УБ, Тус баримтжуулалтын тайланд “Онц байдал ба хүний эрх”-ийн талаар голчлон авсан бөгөөд, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Олон улсын гэрээ конвенцтэй харьцуулан үйл явдалд гарсан зөрчлүүдэд үнэлэлт дүгнэлт өгсөн байна⁷⁵. Мөн IRIM судалгааны хүрээлэн “7 сарын 1 ба хүний эрхийн зөрчил” хэвлэлийн мониторинг хэвлүүлсэн⁷⁶. Тухайн өдөр болон онц байдлын үе, түүний дараах өдрүүдэд Монголын ХМХ-үүд мэргэжлийн өндөр түвшинд ажиллаж чадсан эсэх, ингэж ажиллахдаа хүний эрхийн асуудлыг хэрхэн тусгасныг

⁷¹ Энэ программыг МУИС-ийн ЭЗС-ийн хэрэгжүүлсэн төслийн хүрээнд авсан болно.

⁷² Sneath, D., Kaplonski, C., & Delaplace, G. (2008). *Пост социализмийн төгсгөл? Монгол улсын Улаанбаатар хотод болсон 7 сарын 1-ний үймээн* Дотоод Ази, 2009.

⁷³ “The Role of Trust in Mobilization: Comparing the 'Tulip Revolution' to the July 1 Demonstrations in Mongolia” MIASU Center, Cambridge University, UK 2009

⁷⁴ 3- 5 Sep, 2009 “Civic Movement in Post Socialist Countries” paper, European Society of Central Asian Studies conference, CEU, Budapest, Hungary

⁷⁵ “Онц байдалтай холбоотой хүний эрхийн зөрчлийн мониторинг, хамгааллын эвсэл, *Баримтжуулалтын тайлан*” ННФ, УБ, 2008 он.

⁷⁶ 7 сарын 1 ба хүний эрхийн зөрчил” хэвлэлийн мониторинг ИРИМ судалгааны хүрээлэн хэвлүүлсэн. УБ, 2008 он.

судлах нь тус мониторингийн үндсэн зорилго нь байв. Эмнести Интернэшнл⁷⁷ “Би эндээс хаачих вэ? 2008 оны 7 дугаар сарын 1-ний монголд болсон үйл явдлын сургамж” номонд уг үйд явдалд оролцсон, ямар нэгэн байдлаар хохирсон, амь насаа алдсан иргэдийн ар гэрийнхэн, буудуулж шархадсан хүүхэд, баривчлагдаж эрүү шүүлт, ял тулгуулсан иргэд олон нийтийн яриа зэргийг кейс болгон хүний эрх, эрхзүй, хууль тогтоомж, олон улсын стандарт мөрдлөгүүдтэй харьцуулан судалсан байна. Мөн Ш.Ганболд, Ц.Очгэрэл нар⁷⁸ тухайн үйл явдлын тухай мэдээлсэн сонин, хүмүүсийн яриаг гол болгон хронологи байдлаар бичжээ.

Хамтын зан үйл нь олон түмнийг хамардаг бөгөөд тэдний өдөр тутмын амьдралд байнга тохиолддоггүй зан үйлийн илэрхийлэл тул энэ нь байнга өвөрмөц тайлбарыг социологичдоос шаардаж байдаг. Бид олон янзын тайлбаруудыг харьцуулалгүй Н.Смелзерын “хамтын зан үйл гарч ирэхдээ нийгмийн янз бүрийн урьдчилсан нөхцөл байдалтай заавал тулгардаг. Эдгээр урьдчилсан нөхцөл байдлууд нь дан ганц индивидуал буюу ганцаарчилсан хүнээс биш, харин нийгмийн орчин нь үүнийг бүрэлдүүлдэг юм”⁷⁹, “Эргэлзээгүй тодорхойгүй нөхцөл байдалтай тулгарсан сэтгэлийн хөөрөлд автсан хүмүүсийн тогтсон хэв журмаас гадуурхи үйлдэл юм”⁸⁰ (Смелзер, 1975) гэснийг ашигласан болно. Смелзерийн онолыг бүрэлдүүлж байгаа 6 хүчин зүйлийг нь тус тусад нь тодорхой шалгуурын дагуу задалж долоон сарын нэгний үйл явдлыг анализ хийсэн болно.

С.ҮНДСЭН ТАЙЛБАРЛАЛ

1. БҮТЦИЙН ТОХИРОМЖГҮЙ БАЙДАЛ

Нийгмийн бухимдал: Бүтцийн тохиромжгүй байдлыг тодорхойлох эхний үзүүлэлтийг нийгмийн бухимдал ихэссэнтэй холбон үзсэн. Нийгмийн бухимдлыг харуулах үзүүлэлт болгож долоон сарын нэгний үйл явдлаас өмнөх жагсаал, цуглааныг үйл явдлын шинжилгээний (event study) аргаар өдөр тутмын сонин хэвлэлийг ашиглан тоог нь гаргасан юм⁸¹. Долоон сарын нэгний өмнөх 4 жилийн хугацаанд иргэд олон тооны жагсаал, цуглааныг хийж байжээ. 2004 оны сонгуулиас хойш 2008 оны эхний хагас (сонгуулиас өмнө) хүртэл дөрвөн жил хагасын хугацаанд иргэд, олон нийт нийтдээ 263 удаагийн жагсаал, цуглаан, эсэргүүцэл хийж байсан бол 203 хөдөлгөөн шинээр байгуулагдан идэвхижсэн байна⁸².

График 1. Нийт жагсаал, цуглааны тоо

⁷⁷ “Би эндээс хаачих вэ? 2008 оны 7 дугаар сарын 1-ний монголд болсон үйл явдлын сургамж”. УБ., 2008 он.


⁷⁸ Ш.Ганболд, Ц.Очгэрэл “2008.04 7.01 өчигдөр, өнөөдөр, маргааш”. УБ., 2010 он.

⁷⁹ Н.Смелзер, Социологи 2000.

⁸⁰ Д.Оюунцэцэг (2000) “Олон нийтийн санал бодлын социологи”. УБ., 65 тал

⁸¹ Өдрийн сонин, Өнөөдөр, Зууны мэдээ, Үнэн гэсэн дөрвөн сонинг сонгон авч шинжилгээ хийсэн болно. Энэхүү шинжилгээг ИРИМ хүрээлэнгийн судлаач Э.Эрдэнэбаатар, Б.Эрдэнэ нар голлон хийсэн бөгөөд зарим нэг мэдээллийг МУИС-ийн магистрант Б.Ган-эрдэнэ оруулсан болно.


⁸² Судалгааны урьдчилсан үр дүнг магистрант Б.Ган-эрдэнийн илтгэл, Б.Эрдэнийн магистрын зэрэг хамгаалсан бүтээл дээр ашигласан болно. Харин энэ удаагийн дүн нь тус судалгааны эцсийн үр дүн бөгөөд давхардал зэргийг арилгасан учраас урьдчилсан үр дүнгээс өөр байгаа болно.



Нийт жагсаал цуглаан нь өмнөх дөрвөн жилүүдээс ихээхэн өссөн бөгөөд⁸³ хагас жилээр харьцуулан харуулбал жилийн эхний зургаан сард ихээхэн өсөөд сүүлийн хагас жилд нь арай багассан байна. 2004 оны эхний улирлаас эрчимжсэн иргэдийн идэвхжил 2006 онд хамгийн оргил үедээ хүрч улмаар 2007 онд бага зэрэг буурчээ. Харин 2008 оны эхний хагаст иргэдийн мобилизаци нь багассан боловч хөдөлгөөнүүд шинээр байгуулагдах үйл явц үргэлжилсээр байв. Үүний шалтгааныг олон янзын хүчин зүйлээр тайлбарлаж болох ба эдгээр жагсаал, цуглаан нь цөөнгүй тохиолдолд суулт, мөргөлдөөн, олон нийтийн хүчирхийлэл, өлсгөлөн болж даамжирч байжээ. Цагдаа, хүчний байгууллагуудтай мөргөлдөх, цонх хагалах, зам хаах, дайрах зэрэг хурцдсан хэлбэрүүд ч гарчээ. Энэ бүхэн нь нийгэмд ихээхэн бухимдал байсныг харуулж байна.

Иргэдийн итгэл: Итгэлийг (trust) хоёр үндсэн хэлбэрт судлаачид хуваадаг. Бид энэ тохиолдолд иргэдийн төрийн байгууллагад итгэх итгэлийг бүтцийн тохиромжгүй байдлын нэг чухал үзүүлэлт болгож сонгож авсан болно. Сант Марал сангийн хийсэн судалгаанаас харахад иргэдийн зүгээс төрийн байгууллагад итгэх итгэл 2008 оноос өмнөх жилүүдэд буурсан байгаа нь харагдаж байна.

График 2. Төрийн байгууллагуудад иргэдийн итгэл⁸⁴



Нийгмийн бүлгүүдийн төрийн байгууллагуудад итгэх итгэлийг харвал дунд, дундаас дээд болон нийгмийн дээд бүлгийнхэн төрийн байгууллагуудад илүү итгэж

⁸³ Судалгааны баг нь 2000-2003 оны жагсаал, цуглаан, эсэргүүцлийг бүртгэх ажил хийж байгаа боловч харахан дуусаагүй, боловсруулалтын шатандаа байгаа болно.


⁸⁴ Sumati.L (2010) "Voters' Voices" *People's Perception of Mongolia's Political and Economic Transition as Reflected in Opinion Polls from 1995 to 2007*

байгаа бол нийгмийн доод анги бүлгийхний хувьд төрийн байгууллагуудад итгэх итгэл нь доогуур байгаа бөгөөд шүүх, хуулийн байгууллагад хамгийн бага итгэдэг буюу бараг итгэдэггүй байна. Энэ нь манай шүүх засаглал, төрийн байгууллагын шат дамжлага иргэдэд ил тод бус, ямар нэгэн байдлаар ялгаварлан харьцдагаас болоод нийгмийн доод бүлгийхэн төрийн байгууллагад итгэх итгэл нь сул байгааг харж болох юм.

Хүснэгт 1. Төрийн байгууллагад итгэдэг эсэх. Нийгмийн бүлэг давхаргаар⁸⁵

	Дээд анги	Дундаас дээд анги	Дунд анги	Дундаас доогуур анги	Доод анги	Бүх сонгосон
Ерөнхийлөгчид	75.0%	76.8%	75.8%	70.2%	65.5%	73.3%
УИХ	52.6%	58.8%	54.9%	44.5%	40.2%	51.1%
Төрийн байгууллагууд	45.5%	43.9%	40.5%	34.0%	28.6%	37.8%
Шүүх, хуулийн байгууллагад	40.8%	34.5%	29.9%	23.2%	20.8%	27.8%
Улс төрийн нам	40.6%	36.3%	38.8%	27.9%	26.0%	31.2%

Авлига: Бүтцийн тохиромжгүй байдлыг үүсгэсэн дараагийн хүчин зүйл бол авлига юм.



Трансперанси Интернэшилын авлигын индексээр оноо нь 1 рүүгээ явах тусам авлига ихтэй бөгөөд харин 10 руу дээшлэх тутам ил тод, авлиггүй нийгэм юм. Үүнээс харахад монгол орон нь 1999 онтой харьцуулахад 2004 оноос оноо нь огцом буурч авлига ихэд газар авсан бөгөөд улмаар 2006 онд хамгийн муу үзүүлэлтийг авсан байна.

2. БҮТЦИЙН ХУРЦАДМАЛ БАЙДАЛ

Албан бус мэдээлэл: Сонгууль будлиантай болсон гэсэн албан бус мэдээлэл тарсан нь бүтцийн хурцадмал байдлыг үүсэхэд нөлөөлсөн. 2008 оны зургаан сарын 29-нд болсон зургаа дахь удаагийн сонгуулийн албан ёсны дүн гарахаас өмнө 21 дүгээр тойрог буюу Хан-Уул, Багануур, Багахангай дүүрэг, 25 дугаар тойрог буюу Баянгол дүүргийн санал хураалтын дүн маргаантай тодорхой бус байгаа талаар EAGLE (2008), TV5 (2008) мэдээлж байсан. Ч.Тамирын хронологийн судалгаанаас⁸⁶ үзвэл сонгуулийн будлианы талаар нам хөдөлгөөний тэргүүн болон сонгуулийн штабуудад ажиллаж байсан хүмүүсийн яриа, мөн хэвлэлийн бага хурлууд цаг алдалгүй гарч байсан юм.

Үл ойлголцол: Долоон сарын нэгний үйл явдлын үндсэн сценарид жагсагчдын лидерүүд ба МАХН-ын лидерүүдийн үл ойлголцол бүтцийн хурцадмал байдлыг үүсгэх үндсэн нөхцөл болж өгчээ. Сонгуулийн дүн албан ёсоор гараагүй байхад нам, хүчин, хөдөлгөөний лидерүүд өөрсдийн байр сууриа ХМХ-ээр илэрхийлж, Сүхбаатарын талбай, намын байр болон намын байрны өмнөх талбай, СЕХ-ны гадаа гэх мэт газарт мэдэгдэл хийж байв. Жагсаал эхэлж улмаар олон нийтийн хүчирхийлэл үүссэн тэр үед нам, хөдөлгөөний тэргүүнүүд сонгуулийг

⁸⁵ Sumati.L (2010) "Voters' Voices" *People's Perception of Mongolia's Political and Economic Transition as Reflected in Opinion Polls from 1995 to 2007*

⁸⁶ Ч.Тамир. Долоон сарын нэгний үйл явдлын хронологийн судалгаа. (Хэвлэлтэнд 2011)


булхайгай болсон, зарим тойргуудад сонгуулийг дахин явуулах, саналыг дахин тоолох, энэ бүхний гол буруутан нь МАХН гэж мэдэгдэж байлаа. Жагсаал олон газарт өрнөсөн гэдэг нь бидний судалгаагаар тодорхой байгаа боловч МАХН-ын байрны өмнөх талбайд жагсагчид цагдаа нарын хооронд мөргөлдөөн хурцдаж, нөхцөл байдал хүндэрч байхад лидерүүд асуудлыг шийдэх талаар ямар ч алхам хийсэнгүй. МАХН-ын нарийн бичгийн дарга нар сонгуулийг эсэргүүцэж байгаа иргэдийн эсэргүүцлийг буруушаасан мэдэгдлийг хийв.

Харилцан үйлдэл: Жагсагчид ба цагдаа нарын харилцан үйлдэл нь бүтцийн хурцадмал байдлыг үүсгэх чухал хүчин зүйл болов. Цаг минут тутамд цагдаа нар нэмэгдэж ирж байсан бөгөөд өмнө нь бид зурагтаар л үздэг байсан Америк кинон дээрх шиг л хамгаалалтын жигд хувцас өмссөн олон цагдаа нар иргэдэд ихээхэн содон харагдаж байв. Мөн цагдаа нар урд эгнээнд байсан зарим идэвхтнийг барьсан нь үйл явцыг улам хурцатгаж эхлэв.

3. НЭГТГЭСЭН ИТГЭЛ ҮНЭМШИЛ ТАРХАХ

Сэтгэл зүйн хөөрөл: Смелзерийн онолын дагуу жагсагчдад нэгтгэсэн итгэл үнэмшил бий болж тархах үйл явц нь чухал юм. Үүнийг жагсагчид сэтгэл зүйн хөөрөлд орж юу ч хийхэд бэлэн болсон байгааг зургийн шинжилгээ болон ярилцлаганаас харж болохоор байна. Долоон сарын нэгний үйл явдалд хийсэн зургийн шинжилгээнд нийт жагсагчдын 82.2 хувь нь МАХН-ын талбай дээр байжээ. МАХН-ын талбай дээр байсан нийт лидерүүдийн 33,2 хувьд нь шийдэмгий, 15,2 хувьд нь уурласан бухимдсан байдал ажиглагдаж байсан бол нийт идэвхтнүүдийн 22,6 хувь нь мөн л шийдэмгий, 13 хувь уурлаж бухимдсан байжээ. Эндээс харахад шийдэмгий байгаа байдал нь илүү уурлаж бухимдсан (шүдээ зуусан, харц нь ширүүссэн) үедээ илүү тод илэрч сэтгэл хөдлөлөө гадагш нь гаргаж байжээ. Уурлаж бухимдаж, шийдэмгий байгаа байдал лидерүүдийн хувьд 14:40-өөс 16:10 цагийн үед илүүтэй ажиглагдсан бол 17-цагаас хойш тэд харагдахаа больж идэвхтнүүд багасч дайрагчид ихэсчээ.

График7 . Лидерүүдийн сэтгэл хөдлөл, эмоци



Лидерүүд ба идэвхтнүүдийн уурлаж бухимдаж байсан шалтгаан нь эхэндээ МАХН-ын удирдлага төлөөллийг гарч ирж уулзах, эсвэл жагсагчдын төлөөллийг байшинд оруулах зэрэг шаардлага байсан бөгөөд МАХН-ын байр руу нэвтрэх оролдого хийж байв.

Анхны гал 17 цаг 10 минутанд гарав. Зурагнаас харвал 15 нас ч хүрээгүй гэмээр хоёр хүүхэд газарт тугийг бөөгнүүлж шатаахыг оролдоно. Тухайн гал асаах оролдлогыг томчууд дэмжин тугийг шатааснаар тэнд цугласан хүмүүсийн дуу түрлэг улам нэмэгдэж байна.

Цагдаагийн сэтгэл хөдлөл: Цагдаа нар руу хүн болгон чичилж байсан ба эхэндээ тайван байсан цагдаа нар удалгүй сэтгэл зүйн хувьд хяналтаа алдаж удалгүй хүч хэрэглэж эхлэв. Бичлэг болон зургаас харахад яг энэ үед цагдаа болон жагсагчдын хоорондын мөргөлдөөн тэдний аль аль нь сэтгэл зүйн хувьд хяналтаа алдаж эхэлснийг харуулж байна. Тухайлбал жагсагчид цагдаа нарыг ганц нэгээр барьж авбал нийлж балбаж, харин цагдаа нар нь эргэж дайрч иргэдийг бороохой болон эд зүйлсээр нүдэж

байгаа нь бичлэгээс харагдаж байна. МАХН-ын талбай дээр жагсагчид цугларч эхэлсэн тэр 14 цагаас эхлээд ямар нэгэн хэмжээгээр цагдаа нар хүч хэрэглэж байжээ. Ярилцлага, баривчилгааны үеэр бүрдүүлсэн материалуудаас үзэхэд (онц байдал зарласны дараах цагуудыг оруулаагүй, баривчилгаа эхэлсэн хугацааг оруулаагүй болно) 15:01 цагаас 17:20 цагийн хооронд цагдаа нар жагсагчдад хүч хэрэглэсэн бөгөөд зургийн шинжилгээнд хамрагдсан цагдаа нарын 89,5 хувь нь бороохойтой, 42,9 хувь нь чулуу шидэж байжээ. Энэ нь иргэд жагсагчдыг бухимдуулахад хүргэсэн бөгөөд эргэн довтолох шалтгаан болжээ.

График 8: Иргэдэд аюул учирч болхуйц цагдаа нарын зэвсэг хэрэглэсэн байдал




Галт зэвсэг: Цагдаа нар галт зэвсэг ашиглаж эхэлснээс хойш иргэдийн дунд цагдаа нарыг буруутгаж тэдний эсрэг нэгтгэсэн итгэл үнэмшил үүсэх үйл явц улам хурдсав. Цагдаа нарын хувьд ч гэсэн улайрсан бөгөөд иргэдийн хүчирхийллийг зогсоохын тулд галт зэвсэг зайлшгүй хэрэглэх хэрэгтэй гэсэн итгэл үнэмшил нэгэнт үүссэн бололттой. Удалгүй цагдаа нар буудаж эхэлсэн нь үйл явдлыг бүр хурцатгасан нь эргэлзээгүй.

Цагдаа нарыг ямар зэвсэг, хэрэгсэл яаж хэрэглэснийг нь харвал эхэндээ шилэн бамбай, резинэн бороохой, хамгаалалтын малгай, гавтай байсан бол 15 цагийн үед даралттай ус (МАХН-ын байран дотроос) анх ашиглав. Улмаар 17 цаг хүртэл цагдаа нарын 51.4 хувь нь бороохой, 19 цаг хүртэл цагдаа нарын 85,7 хувь нь даралттай ус, харин 19:05-21:35-ийн хооронд цагдаа нар буу тус тус ашиглажээ. Энэ бүхэн нь жагсагчдын хувьд нэгдсэн итгэл үнэмшил бий болоход нөлөөлсөн байна.

4. ХУРДАСГАГЧ ХҮЧИН ЗҮЙЛ.

Лидерүүдийн уриалга: Сонгуулийн албан бус дүнг улс төрийн намын лидерүүд зарласан нь хурдасгагч гол хүчин зүйл болсон. Үүнд МАХН болон АН-ын сонгуулийн дүнг зарлаж байсан хэвлэлийн бага хурал нь өөрсдийн намыг олонхи боллоо гэж иргэдэд мэдээлэхэд оршиж байв. Ингэхдээ улс төрийн намууд иргэдийг янз бүрээр уриалан дуудаж байсан нь үйл явдлыг хурцатгав.

График 9: Улс төрийн намуудын ХБХ хийлгэсэн, Сүхбаатарын талбайд гарч ярилцсан тоо



Шууд нэвтрүүлэг: Иргэдийг олноороо жагсахад хүргэсэн, олон нийтийг уриалсан дараагийн нэг шалтгаан бол тухайн үйл явдлыг ХМХ-ээр шууд нэвтрүүлж байсан явдал байв. Бараг бүхий л ТВ шууд болон шууд бус байдлаар нэвтрүүлж байв. ИРИМ-ийн хэрэгжүүлсэн уг үйл явдлын мониторингийн төслийн үр дүнгээс харахад МҮОНРТ, Ийгл телевизүүд хамгийн их эфирийн цагийг зарцуулсан байна. Үйл явдлын эхлэл нь 2008 оны зургаан сарын 30-ны 03

цагаас эхлэн сонгуулийн дүнтэй холбоотой ихэнх мэдээ тарж эхэлжээ. Талууд өөр өөрсдийн байр сууринаас тайлбартай болон тайлбаргүй мэдээлж байв. Үүнээс харахад Смелзерийн авч үзсэн хурдасгагч хүчин зүйлд намууд сонгуулийн дүнг албан бусаар зарласан, иргэдийг уриалан дуудсан, мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэл шууд нэвтрүүлсэн нь нөлөөлсөн гэж дүгнэж болохоор байна. Ингэж дүгнэж байгаа нь чөлөөт ХМХ болж байгаа үйл явдлыг түргэн шуурхай, үнэн бодит мэдээллийг нэвтрүүлснийг буруутгаагүй зөвхөн нийгмийн нөлөөллийг нь дүгнэж байгаа хэрэг юм.

График 10: Телевизүүд 7 сарын 1-ний үйл явдалд эфирийн зарцуулсан хувь



5. ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ БҮЛГҮҮД


Жагсагчид: Смелзерийн онолын дагуу иргэд мобилизаци болоход зохион байгуулалттай бүлгүүд чухал үүрэг гүйцэтгэдэг. Жагсаалд оролцож байсан хүмүүсийг урьдчилсан байдлаар идэвхтэн, дайрагчид, ажиглагчид, дээрэмдэгчид хэмээн бид ангилсан юм. Улмаар зургийн судалгаа хийхдээ үүний дагуу оролцогчдыг тооцоолж QDA-miner программаар шинжилгээ хийсэн болно. Одоо эдгээр бүлгүүдийг тус бүрд үндсэн дүр төрхийг зураглан харуулахыг хичээе. Юуны түрүүнд лидерүүдийг авч үзье.

1. Лидерүүд. Үүнд бид иргэний хөдөлгөөний удирдагч нар мөн намуудын дарга нар, олны танил болсон хүмүүсийг авч үзсэн юм. Лидерүүд эхэн хэсэгтээ бусад цагуудаасаа илүү идэвхтэй байж 30,8 хувьтай хамгийн их уриалан дуудаж байсан. 15-17 цагийн хооронд бусад цагуудтай харьцуулахад иргэд болон оролцогчдын үйлдэл хамгийн ихээр идэвхжиж, энэ цагт идэвхтэн, лидерүүд тэдний уриалах байдал нь 28,2 хувьтай байжээ.

2. Идэвхтнүүд. Идэвхтнүүдийн 82,8 хувийг эрэгтэйчүүд, 17,2 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Бүх насны төлөөлөл идэвхтэй оролцож байсан ба насаар нь харвал нийт идэвхтнүүдийн хамгийн идэвхтэй байсан 41,7 хувь нь 18-29 насныхан байсан бол 21,2 хувьтай 30-39 насныхан маань идэвхтэй оролцжээ. Хүүхэд, хөгшчүүд маань ч зүгээр байгаагүй бөгөөд нийт идэвхтнүүдийн бараг арав орчим хувийг тус тус эзэлсэн байна. Тэдний 22,6 хувь нь буюу хамгийн их шийдэмгий, 16,2 хувь үл тоомсорлосон, 15,1 хувь нь тайван, 13 хувь нь уурласан, эсрэгээрээ 11,6 хувь нь баярласан байв.

3. Дээрэмчид. Ашиг хонжоо хайсан, эд зүйл барьсан, галдан шатааж байгаа иргэд анхнаасаа эргэлдэж байсан бололтой. Лавтайяа 19:05-21:35 цагийн хооронд дээрэмчид хамгийн их идэвхжсэн ба энэ хугацаанд архи, вино, виски МАХН-ын байрнаас авч, нэг давхарыг бараг бүхэлд нь галдан шатааж эхэлсэн. Дээрх хугацаанд нийт дээрмийн талаас илүү хувь нь үйлдэгдэж байгаа нь зургийн судалгаанаас харагдаж байна. Тэгвэл 23:01-03:00 цагийн хооронд дээрэмчид 21,4 хувьтай хивс, компьютер гэх мэт эд зүйлс шатааж, энэ цагт гартаа компьютер, хэвлэгч (принтер) зэрэг эд зүйлс авч явж байжээ. Тэдний 98,2 хувь нь эрэгтэйчүүд, 1,8 хувь нь эмэгтэйчүүд гартаа эд зүйлс барьсан, галдан шатааж оролцсон. Дээрэмдэгчдийг насных нь байдлаар авч үзвэл бүх насныхны төлөөлөл байсан ба 51,9 хувь нь буюу талаас илүү нь 18-29 насны залуучууд, 25,9 хувь нь 30-39 насныхан бүрджээ. Тэд шийдэмгий (32,8 хувьтай) үл тоомсорлосон (21,3) байдалтай бөгөөд маш тайвнаар эд зүйлс авч, эвдэж байв.

График 15: Дээрэмдэгчдийн насны байдал



4. Ажиглагчид. Мэдээж талбай дээр ирсэн хүмүүсийн ихэнхи нь ажиглагчид байв. Тэдний 15,3 хувь нь дэмжиж орилж хашгирч байгаа бол ихэнх ажиглагчид ямар нэгэн үйлдэл хийлгүйгээр ажиглаж зогсжээ. Энэ хүмүүсийн 5,3 хувь нь биеэ барьсан, 5,3 хувь нь нуугдсан байдалтай ажиглаж байна. Ажиглагчдын ихэнх нь буюу 68,1 хувь нь эрэгтэйчүүд 31,9 хувь нь эмэгтэйчүүд байжээ. 30-39 насны залуучууд 33,3 хувьтай буюу зонхилж байгаа бөгөөд 18-29 насныхан 26,1 хувьтай байна.

Нүүрээ далдлах: Зургийн судалгаанаас үзэхэд оролцогчид нүүрээ далдалсан байдал нэлээд их гарч ирж байв. Тэд алчуур, хувцас гэх мэт зүйлээр нүүрээ хаажээ. Анх 16 цагийн үед цамц подволкоороо нүүрээ халхалсан 23 орчим насны залуу гарч ирсэн ба тэрээр МАХН-ын байрны хамгийн дээд талын довжоон дээр гарч зогсоод гараа алдлан орилж байжээ. Ингэснээр 18-29 насны залуучуудын үйлдэл идэвхжиж эхэлсэн ба малгайтай цамц, маск алчуураар нүүр амаа харагдахгүй байхаар далдалж эхэлсэн. Бүх насны хүмүүс ямар нэг байдлаар нүүр амаа цамц, подволкоор далдалсан байгаа бөгөөд энэ нь нулимс асгаруулагч хий болон газ цацсантай холбоотой байна. Мөн эмэгтэйчүүд нүүр амаа цамц, подволкоор далдалсан хүмүүсийн 4,3 хувийг эзэлж байгаа бөгөөд өөр ямар нэгэн зүйл ашиглаж нүүр амаа далдлаагүй байгаа нь дээрх шалтгаантай холбоотой болвуу.

График 19: Хэдээс хэдэн цагт оролцогчид юугаар нүүр амаа далдалж байв



Зохион байгуулалт: Зохион байгуулалттай бүлэг үүсэхэд хүрсэн дараагийн шалтгаан бол иргэд өөрсдөө зохион байгуулалтанд орж байсан явдал мөн. Талбай дээр ирсэн байсан жагсагчид сайн дураараа зохион байгуулалтанд орж байсан нь залуучуудын хамгийн их буюу 29.5 хувьтай ганцаараа явж байсан бол, 30-39 насны иргэд 47.5 хувьтай буюу 4-9 хүнтэй зохион байгуулалттай, мөн 10-20 хүнтэй бөөнөөрөө байжээ. Энэ нь дунд эргэм насныхан буюу 30-39 насныхан бусад насныхнаас илүү зохион байгуулалтанд орж байсан ба хүмүүсийн ярьж, хэлж, шүүмжлээд байгаа шиг сэтгэл нь хөөрсөн залуучууд биш ба ямар нэгэн байдлаар тогтсон төлөвшсөн насны хүмүүс зохион байгуулалтанд орж байсан байна. Хүйсийн хувьд эрэгтэй, эмэгтэй аль аль нь зохион байгуулалтад орж байсан ба ямар нэгэн байдлаар хамтарч, цемент ховхолж, төмөр хайс сугалж, тэдгээрийг цааш довтлогчдод дамжуулах гэх мэтээр хамтарч зохион байгуулалтад орж, нарийн хөдөлмөрийн хуваарьт шилжсэнийг зургийн судалгаа харуулж байна.

6. НИЙГМИЙН ХЯНАЛТ АЛДАГДСАН НЬ

Хариу үйлдэл: Смелзерийн онолын дагуу иргэд жагсахад нийгмийн хяналт алдагдсан нь чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Иргэдийн тавьсан шаардлагад хариу өгөөгүй нь хяналт

алдагдахад нөлөөлсөн гэж үзэж болно. Сонгуулийн талаар иргэдийн тавьсан шаардлагад СЕХ, улс төрийн намууд, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд зэрэг хүмүүс ямар нэгэн реакци өгөөгүй, уулзаагүй. Энэ нь хямралын нөхцөл байдалд менежмент хийх чадвар монголын төрийн байгууллагын тогтолцоонд муу байгаа гэдгийг харууллаа. Мөн төрийн байгууллагын удирдах түвшний дарга нарын ур чадварыг муу байгаа гэдгийг нотоллоо. Өөрөөр хэлбэл долоон сарын нэгний үйл явдал нь Монголын төрийн байгууллагууд өөр хоорондоо уялдаа холбоогүй мөн чадавхгүй, цаашид ч гэсэн олон нийтийн жагсаал, цуглааны үед үүссэн аливаа асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй байгааг харуулж байна.

Онц байдал: Монгол улс үндсэн хуулиараа хүний амин чухал эрхийг бүрэн баталгаажуулсан бөгөөд хүний эрхийн талаар соёрхон баталсан хүний эрхийн гэрээ конвенцууд, хуульчлан гаргасан бичиг баримтаараа тэргүүлэх орны нэг болжээ. Харин 2008 оны долоон сарын 1-нд ерөнхийлөгч онц байдал зарлав. Онц байдал зарлах тухай олон улсын конвенцид “Хүний хэд хэдэн эрхийг хязгаарласан хэдий ч хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ямар ч тохиолдолд хүч хэтрүүлэн хэрэглэхээс сэргийлэх” зэрэг чухал санамжуудыг дурдаагүй бөгөөд цагдаа хүчний байгууллагуудад яаж ажиллах журам зааварчилгаа өгөөгүй билээ. Мэдээж анх удаа онц байдлыг зарласан, онц байдлын тухай хууль нь боловсронгуй бус 1995 онд баталсан хуулийн дагуу явагдсан зэрэгтэй холбоотой. Гэхдээ энгийн үед ч төрийн зүгээс иргэдийн эсрэг хүчирхийлэл үйлдэж, эрх, эрх чөлөөнд нь ноцтойгоор халдах эрсдэл өндөр байдаг тул онц байдал зарласан нөхцөлд энэ эрсдэл улам бүр өндөр болох билээ.

ДҮГНЭЛТ

Дээрх судалгаан дээр үндэслэн дараах дүгнэлтийг хийж болохоор байна.

Нэгдүгээрт, нэн тэргүүнд улс төрийн тогтолцоо, төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод хариуцлагатай болгох талаар томоохон реформ хийх цаг болсныг харуулж байна. Төрийн байгууллагуудын хүнд суртал, тэгш бус үйлчилгээ, харьцаа зэрэг нь нийгмийн олонхи болох дундаж, түүнээс доод түвшний амьдралтай иргэдийн төрд итгэх итгэлд сөргөөр нөлөөлж байна. Эндээс төр ба иргэдийн өөр хоорондын харилцаа муу байх нь хамтын зан үйл, жагсаал цуглаан болоход олон нийт идэвхтэй оролцох хөрс суурь болж байна.

Хоёрдугаарт, бодлого боловсруулах бүхий л шатанд иргэдийн мэдээлэх, зөвлөлдөх, шууд оролцох оролцоог баталгаажуулсан хууль эрхийн актуудыг яаралтай батлах хэрэгтэй байна. Тухайлбал жагсаал цуглаан хийж байгаа иргэдийн шаардлагыг хүлээн авч сонсож, зөвшилцөж хамтран ширээний ард сууж асуудлыг шийддэг механизмуудыг баталж өгөх шаардлагатай байна. Смелзер хамтын зан төлөвийн ямар ч илрэлд тус болж буй эсвэл түүнд саад болж буй засгийн төлөөлөгчийн үйлдлээс үйл явдлын хөгжил ямар нэгэн хэмжээгээр хамаарна гэжээ. Тэгвэл долоон сарын 1-нд сонгуулийн талаар иргэдийн тавьсан шаардлагад СЕХ, улс төрийн намууд, ерөнхийлөгч, ерөнхий сайд гээд хүмүүс ямар нэгэн бодитой хариу өгөөгүй, тодорхой шийдвэр гаргаагүй үйл явдалд оролцогчдод хандаж хэлсэн үг, мэдэгдэл зэрэг нь оролцогчдод хүрээгүй зэрэг нь үйл явдал даамжирч хяналтнаас гарахад хүргэсэн байна.

Гуравдугаарт, сонгуулийн хууль тогтоомжийг улам боловсронгуй болгож иргэдийн сонгох сонгогдох эрх чөлөөг хамгаалах, саналын хуудсыг тоолох үйл явцыг аль болох цахимжуулах арга хэмжээ авах хэрэгтэй байна.

Дөрөвдүгээрт, Улс төрийн нам, хүчний удирдлага, тэргүүнүүд сонгуулийн урьдчилсан дүнг албан бусаар зарлаж, ялж байгаа тухайгаа, түүнийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа талаараа өөрсдийн албан ёсны байр сууриа илэрхийлж ХБХ хийлгэж, ярилцлага өгсөн нь иргэдийн дунд үр дүнгийн талаар эргэлзээ үүсч сонгууль будлиантай болсон гэсэн албан бус мэдээлэл тархах үндэс болж хурцадмал байдал үүсэхэд нөлөөлсөн хүчин зүйл болжээ.

Тавдугаарт, улс төрийн нам, хөдөлгөөний лидерүүд аливаа жагсаал цуглааны үеэр өөр хоорондоо зөвшилцөх, харилцан буулт хийх биш харин ч нэгнийгээ үл тоох, сонсохгүй байх, жагсагчдын шаардлагыг үл тоомсорлох зэрэг хандлагууд нь үйл явдлыг даамжруулахад нөлөө үзүүлснийг онцгой анхаармаар байна.

Зургаадугаарт, жагсагчид ба цагдаа нарын харилцан үйлдэл ширүүссэн нь үйл явдлыг хурцаггажээ. Тэгэхлээр цагдаа нарын олон нийттэй харьцах тал дээр онцгой

анхаарч ажиллах, мөн жагсаал цуглааны үеэр жагсагчдын эрхийг хамгаалах үүднээс ажиллах арга туршлагыг нэмэгдүүлэх шаардлагатай юм.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

Монгол хэлээр

“Би эндээс хаачих вэ? 2008 оны 7 дугаар сарын 1-ний монголд болсон үйл явдлын сургамж”. УБ, 2008 он.

Ш.Ганболд, Ц.Очгэрэл “2008.04 7.01 өчигдөр, өнөөдөр, маргааш”. УБ., 2010 он.

7 сарын 1 ба хүний эрхийн зөрчил” хэвлэлийн мониторинг ИРИМ судалгааны хүрээлэн хэвлүүлсэн. УБ, 2008 он.

“Онц байдалтай холбоотой хүний эрхийн зөрчилийн мониторинг, хамгааллын эвсэл, Баримтжуулалтын тайлан” ННФ, УБ, 2008 он.

Д.Оюунцэцэг (2000) “Олон нийтийн санал бодлын социологи”. УБ., 65 тал

Снит, Д. Каплонски, К. Нар Пост социализмийн төгсгөл? Монгол улсын Улаанбаатар хотод болсон 7 сарын 1-ний үймээн Дотоод Ази, 2009.

Н.Смелзер, Социологи 2000.

Ч.Тамир Сонгуулийн булхай. Өнөөдөр 2004 оны 8 сарын 17

<http://forum.mn/old/print.php?coid=455>

Ч.Тамир. Долоон сарын нэгний үйл явдлын хронологийн судалгаа. (Хэвлэлтэнд 2011)

Англи хэлээр

Sumati.L (2010) “*Voters’ Voices*” *People’s Perception of Mongolia’s Political and Economic Transition as Reflected in Opinion Polls from 1995 to 2007*

Tamir Ch. “The Role of Trust in Mobilization: Comparing the 'Tulip Revolution' to the July 1 Demonstrations in Mongolia” MIASU Center, Cambridge University, UK, April, 2009

Tamir Ch. “Civic Movement in Post Socialist Countries” paper, European Society of Central Asian Studies conference, CEU, Budapest, Hungary, Sep 2009